

ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

НЭГ. КОМПАНИЙН ТУХАЙ

Тахько (ХК) компани Монгол улсын Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын 1992 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 32 дугаар тогтоолоор хувьчлагдах шийдвэр гарч, Тахько хувьцаат компани (100 хувь хувийн өмчид шилжсэн) байгуулагдсан үеэс өнөөдрийг хүртэл тасралтгүй үйл ажиллагаа явуулж байна.

Тус компани 1992 онд буюу хувьчлагдах үеийн эхлэлтийн балансаар 345,567.5 мянган төгрөгийн өөрийн хөрөнгөтэй, нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 592,830 ширхэг энгийн хувьцаатай байсан бол 2019 оны жилийн эцсийн байдлаар 15,522,331.5 мянган төгрөгийн хөрөнгөтэй, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй нэг бүр нь 168 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийтэд зарласан чөлөөтэй арилжаалагдах 1,189,983 ширхэг энгийн хувьцаатай нээлттэй хувьцаат компани юм.

ХОЁР. 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Компанийн засаглал

Тахько (ХК) компанийн захиргаа (гүйцэтгэх удирдлага, зохион байгуулалтын нэгжийн албадууд) 2019 онд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал, Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэрийг хэрэгжүүлж, Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, Монголын компанийн засаглалын кодекс, стандартын шаардлагыг мөрдөж, засаглалын үйл ажиллагааг ил тод явуулж ажилласан.

Компанийн захиргаа 2018 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, 2018 оны санхүүгийн тайланд аудит хийлгэсэн PWC хамтарсан Мэдээлэл аудит компанийн дүгнэлт, Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах, аудитын компани сонгох, компанийн 2019 оны төлөвлөгөө, орлого, зардлын төсөв зэрэг асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлж ажиллаж байна.

Компанийн захиргаа Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэрийн дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуульд заасан хугацаа, төрийн зохицуулах байгууллагаас баталсан журамд заасан шаардлагад нийцүүлэн хийж, хүчин төгөлдөр саналын эрхийн 85.75 хувийн ирцтэйгээр хуралдуулж, хурлаар хэлэлцсэн Компанийн 2019 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн

тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох, дотоод ажлын зардлын төсвийг батлах асуудлуудыг хуралд оролцогчдын 100 хувийн саналын эрхээр тус тус батлуулж шийдвэрлүүлсэн.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарсан шийдвэр, холбогдох бусад баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж ХК-д хуульд заасан хугацаанд хүргүүлж, хууль тогтоомж, төрийн зохицуулах байгууллагаас гаргасан журам, хугацааны заалтыг хэрэгжүүлж ажилласан.

2019 онд хуралдсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн 6, хараат бус 3 гишүүн сонгогдсон. Сонгогдсон гишүүд өмнө нь компанийн засаглалын сургалтад хамрагдсан, үүнээс хараат бус гишүүд нь Компанийн хуульд заасан шаардлага, шалгуурыг бүрэн хангаж байгаа бөгөөд сонгогдсон гишүүдийн тухай мэдээллийг Хөрөнгийн биржийн болон компанийн цахим хуудсаар олон нийтэд мэдээлсэн болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр (ТУЗ-ийн 2020.02.18-ны № 01 тогтоол)-ийн дагуу компанийн 2019 оны цэвэр ашгаас 1,187,883 ширхэг энгийн хувьцаанд хуваарилсан 128,518.2 мянган төгрөгийн ногдол ашгаас хувь хүн ба аж ахуйн нэгжийн орлогын албан татварт 6,425.9 мянган төгрөг суутган харьяалах татварын байгууллагад шилжүүлэн тайлагнаж, 115,447.7 мянган төгрөг (Үүнээс 110,627.0 мянган төгрөгийн ногдол ашгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв компаниар зуучлуулан, 4,820.7 мянган төгрөгийн ногдол ашгийг компани дээр тус тус олгож)-ийн ногдол ашгийг бүртгэлийн өдрөөр ногдол ашиг хүртэх эрхтэй 630 хувьцаа эзэмшигчдийн төвлөрсөн хадгаламж дахь дансанд 2019 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр байршуулж, хууль, журам, гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид тогтоосон хугацаанд тайлагнаж, хувьцаа эзэмшигчид болон олон нийтэд мэдээлсэн.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1-20.1.10, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 443 дугаар тогтоолоор баталсан Мэдээллийн ил тод байдлын журмын 1.2-1.3, 2.2, 3.1, 3.3, Монголын хөрөнгийн биржийн бүртгэлийн журмын 21.1-21.9, Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн 2019 оны 1/22 тоот хамтран ажиллах бичгийн 1-4, мөн бичгийн хавсралт мэдээллийн хуанлийн 13 заалтыг тус тус хэрэгжүүлж санхүүгийн ба санхүүгийн бус тайлан, хугацаат ба тухай бүр мэдээлэх мэдээллийг хувьцаа эзэмшигч, олон нийт, зохих байгууллагуудад тогтоосон хугацаанд мэдээлэх үүргийг биелүүлж ажилласан.

Компанийн веб хуудасны мэдээ мэдээллийг тухай бүрт нь шинэчилж, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын зар, хэлэлцэх асуудал, хурлаас гарах шийдвэрийн төсөл, Хувьцаа эзэмшигчдийн болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэр, компанийн бусад мэдээллийг мэдээлж, хувьцаа эзэмшигч болон олон нийтийг мэдээллээр хангах үүргийг биелүүлэн ажиллаж байна.

2019 онд их хэмжээний ба сонирхолын зөрчилтэй гэрээ хэлцэл хийгдээгүй, үнэт цаасны ханш, арилжааны хэмжээнд мэдэгдэхүйц нөлөөлөх нөхцөл байдал үүсч бий болоогүй болно.

Компани 2019 онд Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржийн тогтоол, шийдвэр, журмаар тогтоосон нээлттэй хувьцаат компанид холбогдох заалтууд болон үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажилласан.

Тахько (ХК) компани 2019 онд компанийн засаглалын зарчим, үйл ажиллагааг хэрэгжүүлж Монголын хөрөнгийн биржийн Үнэт цаасны бүртгэлийн журмын 12 дугаар зүйлийн 12.1-ийн 12.1.1-12.1.4, 12.2-ын 12.2.1-12.2.4 дэх хэсэгт заасан үнэт цаас гаргагч болон үнэт цаасны шалгуур (тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа, санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (IFRS)-ын дагуу гаргах, Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрөлтэй аудитын байгууллагаар баталгаажуулах, үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах хангалттай хэмжээний ажлын капиталтай байх эсхүл 100 сая төгрөгөөс доошгүй хэмжээний ашигтай ажилласан, компанийн засаглалын зарчмыг дагаж мөрддөг, компанийн зах зээлийн үнэлгээ, гаргасан үнэт цаасны нийтэд санал болгосон хувь, компани нь засаглалын болон мэдээллийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх зэрэг)-ын дагуу хоёрдугаар ангиллын нээлттэй компанийн шаардлагыг хангаж байна.

Компанийн бүтэц, зохион байгуулалт

Компани 2019 онд Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлага, Захиргааны болон Техник үйлчилгээний алба гэсэн бүтэцтэй ажилласан.

Компанийн 2019 онд мөрдөх орон тоо, албан тушаалтны үндсэн цалингийн хэмжээг Гүйцэтгэх захирлын 2019.01.02-ны өдрийн 01 дүгээр тушаалаар баталж, байнгын ажлын байрны 27 орон тоо (ТУЗ-ийн дарга, нарийн бичгийн дарга ороод)-той ажиллахаар төлөвлөж, 26 орон тоо (Эдийн засагч, төсөл хөтөлбөр, тооцоо судалгаа хариуцсан мэргэжилтний орон тоонд хүн ажиллуулаагүй)-оор ажилласан.

Ажилтнуудтай байгуулсан Хөдөлмөрийн гэрээгээр тохиролцсон ажлын байрны үндсэн цалингийн хэмжээг мөрдөж, тэдний ажлын үр дүнг харгалзан Гүйцэтгэх захирлын 2016 оны 16 тоот тушаалаар баталсан журмын дагуу улиралд нэг удаа үндсэн цалингийн 40 хүртэл хувийн урамшуулал олгож байна. 2019 онд ажилтнууд, удирдлага, ТУЗ-ын гишүүдийн цалин урамшуулалд нийтдээ 959,416.9 мянган төгрөг олгож, цалингийн зардал компанийн нийт зардлын 33 хувь болсон.

Компанийн 2019 оны санхүүгийн тайланг “А” форматаар болон санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (IFRS)-ын дагуу гаргаж, Прайсуотерхаускуперс аудит ХХК-аар олон улсын түвшингийн аудитын баталгаажуулалт хийлгэж, Төлөөлөн удирдах зөвлөл болон 2019 оны Хувьцаа



эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэн батлуулж, дүгнэлт тайланг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хүргүүлсэн.

Компани, Компанийн дүрмээр олгосон эрх хэмжээний хүрээнд өмч хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээ, компанийн хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой хангамжийн материал, сэлбэг хэрэгслэл, түлш шатахуун худалдан авах, хөрөнгийн их болон урсгал засвар хийх, үйлчилгээ үзүүлэх зэрэг компанийн өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр сонголт хийсэн ажил гүйцэтгэгчидтэй 64 гэрээ байгуулж, тэдгээр гэрээгээр гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ, ажлын үр дүнг зохих журмын дагуу актаар хүлээн авч, төлбөр тооцоог хийж дуусгасан.

Компанийн өмч хөрөнгийг эрсдэлээс хамгаалах зорилгоор Практикал даатгал компанитай үл хөдлөх хөрөнгийн даатгалын гэрээ шинээр байгуулж, бүх төрлийн даатгалын гэрээнүүдийн дагуу 2019 оны даатгалын хураамжинд 10.967.2 мянган төгрөг төлсөн байна.

Оёдлын үйлдвэр, компаниас өндөр насны тэтгэвэрт гарсан Хөдөлмөрийн баатар, гавьяат ажилтан болон өндөр настай 21 ахмад настанд цагаан сарын баярыг тохиолдуулан хүндэтгэл үзүүлж, ахмад настан Хөдөлмөрийн баатар 2 хүнд, Аж үйлдвэрийн гавьяат ажилтан 1 хүнд, гачигдал тохиолдсон ахмад настан 5 хүнд нийтдээ 13,266.7 мянган төгрөгийн буцалтгүй тусламж олгосон болно.

Хүний нөөц, нийгмийн хариуцлагын асуудал

Компани тайлангийн хугацаанд 26 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж, тэдгээр ажилтнууд хууль тогтоомжид зааснаар давхардсан тоогоор ажлын 6,526 өдөр ажиллахаас 5,447 өдөр ажиллаж, 26 ажилтан 484 өдрийн ээлжийн амралт биеэр эдэлж, гачигдал тохиолдсон 8 ажилтанд давхардсан тоогоор 30 өдрийн захиргааны чөлөө олгож, 2 ажилтан хөдөлмөрийн чадвар түр алдаж 27 өдрийн ажлаас чөлөөлөгдсөн байна.

Байнгын ажлын байрны 22 ажилтантай 2018 онд байгуулсан Хөдөлмөрийн болон эд хөрөнгийн бүрэн хариуцлагын, нууц хадгалах гэрээнүүдийг дүгнэж, тэдгээр гэрээний хугацааг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаагаар сунгасан. Компани Хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн ажил олгогчийн үүргээ биелүүлэн ажиллаж байна. Өндөр насны тэтгэвэр тогтоолгох болсон Засварчин, өөрөө хүсэлт гаргасан Нягтлан бодогч нарын Хөдөлмөрийн гэрээг цуцалж, ажлаас чөлөөлж, ажлыг хүлээн авч компанитай хийх тооцоог дуусгасан. Мэргэжлийн нягтлан бодогч нэг иргэнтэй жирэмсний амралтаа авсан Ерөнхий нягтлан бодогчийн жирэмсний ба амаржсаны амралт болон хүүхдээ асрах хугацаанд Ерөнхий нягтлан бодогчоор томилж хөдөлмөрийн гэрээг, шинээр нэг хүнийг нягтлан бодогчоор туршилтын хугацаагаар томилж, туршилтын хугацааны хөдөлмөрийн гэрээг тус тус байгуулан ажиллаж, үндсэн ажилтнаар томилон ажиллуулж байна.

Нийт ажилтнуудын ажлыг Хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүрэг, ажлын байрны тодорхойлолтын чиг үүргийн дагуу

улирал тутам дүгнэж, ажлын тайлан бичүүлж, 2019 онд ажлын байрны тодорхойлолтоор хүлээсэн ажил үүрэг, хөдөлмөрийн гэрээ, дотоод журмын зарим заалтыг бүрэн биелүүлээгүй гэж үзсэн 11 ажилтан (нэг жолооч, захирлын туслах, дөрвөн цахилгаанчин, гурван засварчин, нэг үйлчлэгч)-ны цалингийн урамшууллыг 5-40 хувиар хасч ажлын хариуцлагыг дээшлүүлэх хөшүүрэг болгон ажиллаж, ажлын байрны тодорхойлолтод заасан үүрэг, хөдөлмөрийн дотоод журмын заалтыг хангалтгүй биелүүлсэн нэг ажилтанд Гүйцэтгэх захирлын 2019.11.20-ны 57 дугаар тушаалаар ажлаас халахыг сануулж сахилгын шийтгэл ногдуулсан болно.

Нэг менежерийг Удирдлагын академид бизнесийн удирдлагын магистрын, Ерөнхий нягтлан бодогчийг татварын хууль тогтоомжийн шинэчлэл, татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн эрх олгох, PwC аудитын байгууллагын татварын шинэчилсэн хуулиуд ба тэдгээрийн бизнест нөлөөлөх нөлөөлөл зэрэг ээлжит сургалтууд, Ерөнхий нягтлан бодогч, нягтлан бодогч нарыг PwC аудитын IFES тайлангийн тасралтгүй хөгжлийн сургалт, Техник үйлчилгээний албаны дарга, инженер нарыг мэргэшсэн зөвлөх инженер төсөвчний, Цахилгаанчинг мэргэшсэн инженерийн зэрэг горилох, цахилгаанчин, засварчин 9 ажилтныг аюулгүй ажиллагааны эрх сунгах ба мэргэжлийн тасралтгүй ажиллагааны сургалтанд тус тус суралцуулсан. Сургалтанд нийт 9,013.8 мянган төгрөг зарцуулсан.

Гачигдал тохиолдсон ажилтан (Менежер, сантехникийн засварчин, жолооч, инженер, үйлчлэгч, нярав, архивын эрхлэгч, захирлын туслах)-уудад Хөдөлмөрийн дотоод журамд заалтыг үндэслэн нийтдээ 11,722.2 мянган төгрөгийн буцалтгүй, Ерөнхий нягтлан бодогчид компанитай байгуулсан гэрээний дагуу 83,333.3 мянган төгрөгийн тусламж олгож ахуй амьдралд нь тусалсан.

Ажилтнуудын ерөнхий мэдлэгийн түвшинг дээшлүүлэх болон цаг үеийн мэдээллээр хангах зорилгоор эрхэлсэн ажил, хууль тогтоомж, эрүүл мэндийн даатгал, иргэний бүртгэл, албан татвар, компанийн дотоод ажил, хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилт зэрэг асуудлаар сар тутамд 2 удаа сонсгол, мэдээлэл хийсэн.

Хамт олон өөрсдийн санаачлагаар эрүүл мэнд, бие бялдраа чийрэгжүүлэх зорилгоор сагс, гар бөмбөгийн тоглолтыг 7 хоногт нэг удаа хийж, баг хоорондын тэмцээн явуулж байгаа бөгөөд энэхүү үйл ажиллагааг дэмжин компаниас дүүргийн 50 дугаар сургуультай 2 удаа гэрээ байгуулан заалны төлбөрт 2,280.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

Ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор нийт ажилтнуудыг Сөүл сонгдо эмнэлэгт нарийн мэргэжлийн урьдчилан сэргийлэх багц үзлэг, шинжилгээ оношлогоог компанийн зардал (4,600.0 мянган төгрөг)-аар хийлгүүлж, эрүүл мэндийн зөвлөгөө өгүүлсэн.

Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд Монголын анхны сэхээтнүүдийн тухай судалгааны үйл ажиллагааг дэмжиж, "Найрагчийн мөрөөр" телевизийн нэвтрүүлэг бэлтгэх ажилд 1,500.0, Нийгмийн хөгжил бидний ирээдүй ТББ-ийн чиглэлээр Говь-Алтай аймгийн Эрүүл Алтай хөтөлбөр, Архигүй Алтай

хөтөлбөрт 21,000,0, Монгол ардын 100 уртын дууг дуулж нийтийн хүртээл болгох ажил үйлсийг нь дэмжиж Монгол улсын соёлын гавъяат зүтгэлтэн С.Эрхэмбаярт 1,111.1 мянган төгрөгийн, УСУГ-ын 60 жилийн ойд 4 ажилтанд 1,333.3 мянган төгрөгийн хандив олгосон.

ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ, ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХ

Компанийн орлого нэмэгдүүлэх, бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр

Компанийн бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор бүх төрлийн хог хаягдал, нүүрснээс шингэн түлш болон цахилгаан гаргаж авах төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг үргэлжлүүлэн дараах ажлыг хийсэн.

Төслийн ажлын хүрээнд Япон улсын “GGI TRUST” компанитай 2019 оны 04 дүгээр сарын 15-нд Тоног төхөөрөмж худалдан авах гэрээ байгуулан туршилтын төслийн үндсэн төхөөрөмж, ус зөөлрүүлэгч, ус эргэлдүүлэх төхөөрөмж түүний сэлбэг, эд ангийг худалдан авсан. Мөн “GGI HONG KONG” компанитай 2019 оны 04 дүгээр сарын 01-нд Худалдааны ерөнхий гэрээ байгуулж ус цэвэршүүлэх төхөөрөмж, ус цэвэршүүлэгчийн толгой, шүүлтүүр худалдаж авсан.

Төслийн ажилд шаардлагатай тусгай зөвшөөрлүүдийн судалгаа хийж, холбогдох материалуудыг бэлтгэж, зөвшөөрөл авах ажилтай холбогдолтой хуулийн зөвлөх үйлчилгээ мөн ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллаж байна.

Төслийн ажилд хэрэглэхээр Япон улсаас худалдан авах нийлэгжүүлэх бодисын нарийвчилсан шинжилгээг Гаалийн ерөнхий газрын баталгаат лабораторт хийлгэж, БОАЖЯ-ны тусгай зөвшөөрөл авахаар хөөцөлдөж байна.

Төслийн ажлыг эхлүүлэхэд шаардагдах хаягдал тосны судалгаа хийж, сайн чанарын техникийн хаягдал тос худалдах худалдан авах гэрээ байгуулан худалдан авсан.

Төслийн ажил эхлүүлэхэд шаардлагатай дизель түлш худалдан авахаар дотоодын компаниудтай урьдчилсан уулзалтууд хийж худалдан авахаар төлөвлөсөн боловч валютын ханш, үнийн өсөлтөөс болж 2019 онд худалдан авах боломжгүй болсон.

Япон улсаас төсөлд шаардлагатай нийлэгжүүлэх бодисыг худалдан авах ажил БОАЖЯ-ны тусгай зөвшөөрөл гараагүй учир 2020 онд худалдан авахаар хойшлогдсон.

Төслийн үйлдвэр барих газрын төлбөр өөрчлөгдөж, газрын гэрээ шинэчлэх, гэрчилгээ солиулах ажил Дархан-Уул аймгийн Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын шийдвэр гараагүй байгаа тул газрын төлбөр төлөгдөөгүй хүлээгдэж байгаа болно.

Үйлдвэрийн газрын хашаа, контейнер зэрэг эд хөрөнгийн харуул хамгаалалтын ажлыг иргэнтэй хөлсөөр ажиллах гэрээгээр гүйцэтгүүлж, ажлын хөлсийг төлж байгаа болно.

Төслийг эхлүүлэх ажлын хүрээнд Дархан-Уул аймагт 5 удаа, Япон улсад 2 удаа томилолтоор ажилласан.

Компанийн ирээдүйн хөгжлийн архитекторын ажлын зураг хийх ажил Өндөр барилга, газар хөдлөлийн урьдчилсан арга хэмжээ, тооцооны мэргэшлийн зөвлөлийн хурлаар 2019 оны 08 дугаар сарын 23-нд орж дэмжигдсэн. Мөн Монголын барилгын үндэсний ассоциацийн тусгай зөвшөөрөл олгох асуудлаар урьдчилсан дүгнэлт гаргах ажлын хэсгийн 2020 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн хурлаар дэмжигдсэн.

Компанийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр

Их засварт

Компанийн үндсэн хөрөнгө, барилга байгууламжийн хэвийн ажиллагааг хангах зорилгоор мэргэжлийн гүйцэтгэгч компаниудтай гэрээ байгуулан дараах их засварын ажлыг гүйцэтгэсэн. Үүнд:

- МА-II барилга (ТЕДИ төв)-ын 2, 3, 4 дүгээр давхарт Солонгос улсын LG компанийн LG Multi-V системийн эйркондишн шинээр худалдан авч суурилуулах (эйркондишний иж бүрдэл, хөргөлтийн болон конденсацйн усны шугам хоолойн угсралт, сигнал, удирдлагын болон цахилгааны кабель, тааз хайрцаглах, бусад ажил) ажлыг 332,091.0 мянган төгрөгийн;
- МА-II барилга (ТЕДИ төв)-ын 1-4 дүгээр давхарт хэрэглээний халуун усны шугам хоолой шинээр татаж, Солонгос улсын GK23-26H маркын халуун усны ялтсан бойлер суурилуулах ажлыг 69,782.4 мянган төгрөгийн;
- МА-I барилга (оффис)-ын 2 дугаар давхрын таазны ердийн гэрэлтүүлгийг эрчим хүчний хэмнэлттэй LED (Lonon LED LN-PL36W-04S загварын, гэрэлтүүлэгийн хэмжээ нь 80 Lm/W-аас багагүй 60*60 см хэмжээтэй) гэрлээр солих ажлыг 12,679.0 мянган төгрөгийн;
- МА-I барилгын дэргэдэх автомашины гарааш (Мобиком корпораци ХХК-иас худалдаж авсан)-ийн барилгын дээврийн засварын ажлыг 8,845.4 мянган төгрөгийн;
- Гурвалжин дахь аж ахуйн агуулахын дотор талын 2,350 м² хана таазыг шүршдэг базальтвүүл чулуун хөвөн дулаалгын материалаар дулаалах засварын ажлыг 54,495.4 мянган төгрөгийн, U-I барилгын 1 дүгээр давхрын 45 м² цонхыг вакуум цонхоор солих ажлыг 8,475.0 мянган төгрөгийн;
- мөн барилга (Тахько компанийн өмчлөлийн)-ын сольж суурилуулах цахилгаан шат (Shanghai Edunburgh Elevator үйлдвэрийн EN8120:2014, EN81-50:2014 маркын)-ны захиалгын урьдчилгаа төлбөрт 4,065.5 мянган төгрөгийн;

Нийтдээ 490,433.9 мянган төгрөгийн их засварын ажил хийж гүйцэтгэсэн.

Урсгал засварт

МА-I барилгын 2 дугаар давхрын хүзүүвчинд хаалгатай шилэн хаалт хийх, U-I барилгын 1 дүгээр давхрын болон засварчдын өрөөний вакуум цонх солих, Анкор төвийн агааржуулалт, эйр кондишны засвар, МА-I барилгын 1 дүгээр давхрын хүзүүвчийн гэрэлтүүлэг сольж, мөн давхрын хаалган дахь халуун хөшгөнд дулаан мэдрэгч бүхий удирдлагын самбар суурилуулах, автомашины гараашийн жижиг хэсгийн гэрэлтүүлэг, цахилгааны утас, аж ахуйн агуулахын гаднах болон доторх гэрэлтүүлэг шинэчилж солих, харуулын байрны кабель татах, засварчдын өрөөний цахилгааны монтаж шинэчлэх, Анкор төвийн үүдний хэсэгт 380В кабель татаж цахилгаан халаагуурыг шинэчилж, дулаан мэдрэгчтэй удирдлагын самбарын холболт хийх, МА-I барилгын дулааны холигч үзелийн автомат ба балансын хаалт тохируулагч солих, МА-III барилгын хүйтэн усны Ф100 шугам солих, МА-I, МА-II барилгын халаалтын шугамын дулаалга, U-I барилгын 1 дүгээр давхарт хэрэглээний халуун усны шугам шинээр татах зэрэг 71,172.2 мянган төгрөг (үүнээс 17,994.1 мянган төгрөгийн барилгын, 19,557.2 мянган төгрөгийн цахилгааны, 33,620.9 мянган төгрөгийн сантехникийн)-ийн урсгал засварын ажил хийж гүйцэтгэсэн байна.

Хэвийн үйл ажиллагааг хангах өдөр тутмын ажил

Цахилгаан эрчим хүчний гадаад, дотоод тооцооны нийт 50 гаруй тоолуурын заалтаар цахилгаан эрчим хүчний хэрэглээний тооцоог тогтмол хийж, 337,949.4 мянган төгрөгийн цахилгаан эрчим хүчний үнийг хэрэглэгчдэд хувиарлан төлүүлсэн. Үүнд: цахилгаан 309,844.6, цахилгааны тоолуурын зөрүү 1,291.8, тарифийн зөрүү 14,438.0, үйлчилгээний үнэ 12,375.0 мянган төгрөгийг хэрэглэгчдэд хуваарилж төлбөрийг хийлгэсэн.

Дулааны төлбөрт 58,995.2, үйлчилгээний төлбөрт 1,208.3, цэвэр бохир усны төлбөрт 34,093.7, усны үйлчилгээний төлбөрт 1,266.5, телефон ярианы төлбөрт 1,589.0 мянган төгрөгийг хэрэглэгчид хуваарилан төлүүлсэн байна.

Үндсэн хөрөнгийн өөрчлөлт, элэгдэл хорогдлын шимтгэл, сэлбэг, аж ахуй, барилга, хангамж, шатах тослох материал, кассын тооцоонд хяналт тавьж, анхан шатны баримтын бүрдүүлэлтийг бүрэн хийлгэж, тайлан бүртгэлийг зохих журмын дагуу хөтөлж ажилласанаар ямар нэгэн зөрчил дутагдал гараагүй, бэлэн мөнгөний зарцуулалт, түүнд тавих хяналт хэвшсэн болно.

Компанийн үндсэн үйл ажиллагаа болох түрээсийн орлогыг бүрдүүлэх ажлыг гэрээний дагуу хийж, түрээслэгч компаниудтай тооцоо нийлж ажилласнаар түрээсийн орлогын төлөвлөгөө 100 хувиар, цахилгаан, дулаан, цэвэр бохир усны зэрэг харилцагч байгууллагуудын хэрэглэсэн хэрэглээний төлбөрийн үндсэн бус үйл ажиллагааны орлого 91.9 хувиар тус тус биелсэн.

Ажлын байр, ажиллах нөхцөлийг хангах болон бусад

Ажлын нөхцөлийг хангах зорилгоор 117,382.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө (Toyota ачааны автомашин, ус цэвэршүүлэгч, компьютер камерийн

дэлгэц, контейнер), 68,5 мянган төгрөгийн хангамжийн материал худалдан авч бэлтгэсэн.

Компанийн оффисын болон мэдээллийн системийн хэвийн сааталгүй ажиллагааг хангах зорилгоор Ай Ти аутсорсинг ХХК-тай гэрээгээр хамтран ажиллаж, интернет, компьютерын болон камерын төхөөрөмж, Wireless access point төхөөрөмж, Unifi controller серверийн өдөр тутмын үйлчилгээ хийлгэн ажиллаж байна.

Хуучин системийн 4 ширхэг IP камерыг Hikvision брендийн камераар сольж бүх камерыг нэг системтэй болгосон. Компанийн төв оффис, гурвалжин дахь аж ахуйн хашаа, агуулах, компанийн нутаг дэвсгэр, Анкор төв, автомашины гарааш, дулааны үзель, цахилгааны ХТП 0477 дэд өртөө зэрэг гадна болон дотор талд хяналт тавих 24 цагаар ажилладаг нийт 28 камерийн тохиргоо үйлчилгээг тогтмол хийж хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна.

Компанийн санхүүгийн тайлан тэнцэл, аж ахуйн нэгжийн орлогын, хувь хүний орлогын, үл хөдлөх эд хөрөнгийн, авто тээвэр өөрөө явах хэрэгслийн, нэмэгдсэн өртгийн албан татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан тооцоог тогтоосон хугацаанд нь гаргаж, хуульд заасан хугацаанд харилцдаг санхүү, татвар, нийгмийн даатгалын байгууллагад тушааж, тайлангийн хугацаанд улсын төсөвт 131,588.5 мянган төгрөгийн аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, 181,560.6 мянган төгрөг (үүнээс 119,471.6 нь компаниас, 62,089.0 нь даатгуулагчаас)-ийн нийгмийн даатгалын шимтгэл, 113,047.7 мянган төгрөг (ажиллагсдаас суутгасан 87,786.5 ажил үүрэг гүйцэтгэгчээс суутгасан 12,417.6, ногдол ашгаас суутгасан 12,843.6 мянган төгрөг)-ийн хувь хүний орлогын албан татвар, 28,456.9 мянган төгрөгийн үл хөдлөх хөрөнгө, газар болон авто тээврийн болон өөрөө явагч тээврийн хэрэгслийн албан татвар, 211,968.0 мянган төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татвар төлж, улсын төсөвт төлөх төлбөрийн 97,4 хувийг тайлангийн хугацаанд барагдуулсан байна.

Компанийн өмч хөрөнгийн 2019 оны жилийн тооллого явуулж, 13,465,925.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 12,269.0 мянган төгрөгийн бараа материал, 23,441.1 мянган төгрөгийн хангамжийн материал тоолж, хуучирч ашиглагдахгүй болсон, ашиглалтад олгогдсон, өөрийн өртөггүй болсон зэрэг 67,588.6 мянган төгрөгийн хөрөнгө актлав.

Компани 2019 онд 3,550,449.6 мянган төгрөгийн орлоготой, 2,947,504.7 мянган төгрөгийн зарлагатай, 489,015.4 мянган төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажиллаж, 2018 оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулахад компанийн орлого 53,451.1 мянган төгрөг буюу 2 хувиар өсч, зардал 2,947,504.7 мянган төгрөг буюу 12 хувиар өсөж, хуримтлагдсан ашиг 4,836,892.5 мянган төгрөг болж 6.9 хувиар өссөн байна.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  ЛЭНХНАСАН